

ТӨВ АЗИД ДЭЛГЭРСЭН АЛЕКСАНДРЫН ДОМОГ^{1, 2, 3}

John Andrew Boyle

Орчуулсан Ц.Отгонсүрэн
Хянан зөвлөсөн Б.Отгон (БНХАУ, БХҮИС)

НТӨ⁴ 323 онд Аугаа Александрыг таалал болсноос хойш түүний суу алдар, байгуулсан гавьяатай эн зэрэгцэхүйц үйл явдал өрнө, дорнын түүхэнд гарсан удаагүй. Тухайн цаг үед бичсэн зохиолууд бүрэн эхээрээ хадгалагдаж үлдээгүйгээс гадна Александрыг нас нөгчсөнөөс хойших бүтэн 450 гаруй жилийн хугацаанд бичигдсэн зохиолуудад тулгуурлан Арриен⁵-ны бичсэн *Анабасис*⁶ (the Anabasis of Arrian) гэхэд л дундад зууны үеийн зохиолчдод бараг бүхэлдээ танигдаагүй ч оюун санааны хувьсал⁷ (the Revival of Learning)⁸ гэсэн хэсэг л барууны эрдэмтдийн хүртээл болж чадсан. Аугаа Александрын алдар нэр Александрын

¹ Энэхүү өгүүллийг 1974 оны 6-р сарын 12-ны өдөр Аманзохиолын Нийгэмлэгт анх уншсан.

² БНХАУ, Баруун Хойтын Үндэстний Их Сургуулийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн профессор Б.Отгон (PhD)-ны удирдсан “The major project of China’s National Social Science Fund: Translation and Comparative Study of Catalogues of the Mongolian Documents in Russian Collections (Project No.18ZDA323)” төслийн хүрээнд Македоны Александр III (Аугаа Александр, НТӨ 365-323)-т холбогдох сурвалжууд болон баримт сэлтийн талаар дорнодахины судлаач, түүхч, Британийн эрдэмтэн JOHN ANDREW BOYLE (1916-1978)-ийн бичсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдийг орчуулан, зохиогчийн бичсэн он цагийн дарааллаар цуврал болгон хүргэж байна. Эдгээр өгүүллийг орчуулах явцад холбогдох тайлбар, үг, хэллэг, нэр, нэршлийг орчуулж, галиглан буулгахад мэргэжлийн зөвлөгөө өгсөн МУИС-ийн, ШУС-ийн, ХУС-ын багш Б.Азаяа, Б.Арьяажав, Ц.Баттулга, Г.Бат-Учрал, С.Булгантамир, Н.Гэрэлмаа, Б.Пүрэвсүрэн, Г.Эрдэнэнаран нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

³ Эл өгүүллийг орчуулах явцад хийсэн тэмдэглэгээний талаар энд товч тайлбарлая. Үүнд: 1. Сэтгүүлийн техник шаардлагад нийцүүлэн уг өгүүллийн зохиогчийн зүгээс тухайн бичвэрт холбогдох зүүлт, тайлбарыг хийснийг бүхэлд нь тод хэлбэр (**bold**)-ээр онцгойлон ялгаж, харин орчуулагчийн зүгээс хийсэн тайлбар (аль (монгол, англи)-ыг үндсэн хэлбэр (regular)-ээр бичив; 2. Оноосон нэр тус бүрийг галиглахдаа тухайн нэрийн холбогдох цахим бичвэрт тэмдэглэсэн дуудлагыг баримталсан бөгөөд ард нь хаалт “()”-ны дотор уг эхийг хадгалах үүднээс өгүүлэл дэх тухайн оноосон нэрийн язгуур хэлбэрийг хэвээр нь бичиж, зарим нэр хийгээд хэрэг явдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүссэн судлаачид, уншигчдад зориулан хөл тэмдэглэгээг давхар хийж, холбогдох цахим хаяг болон бусад эх сурвалжийг оруулав; 3. Зарим эх сурвалж буюу зохиолын нэрийг орчуулснаас гадна уг өгүүллийн зохиогч үсгийн налуу хэлбэрээр ялган тэмдэглэсэн хийгээд оноосон нэр болон зарим тодотгол зэргийг том үсгээр тэмдэглэсэн, мөн түүнчлэн догол мөр, хоосон зай үлдээсэн зэргийг тус тус хэвээр нь үлдээв.

⁴ Нийтийн Тооллын Өмнөх.

⁵ Бүтэн нэр нь Lucius Flavius Arrianus бөгөөд англи хэлнээ ихэвчлэн Arrian гэнэ. Түүний төрсөн он тодорхойгүй ч НТ-ын 85-90 оны хооронд, харин таалал болсон хугацааг 145/146 оны дараа гэж үздэг. <https://www.livius.org/sources/content/arrian/>

⁶ Аугаа Александрын аян дайны түүхийг өгүүлдэг. https://en.wikisource.org/wiki/The_Anabasis_of_Alexander

⁷ Хүний оюун санаанд аяндаа бий болдог хувьсал, өөрчлөлт. <http://medievalcostumesandgifts.com/medieval-blog/tag/revival-of-learning/>

⁸ Энэхүү зохиолыг хүмүүнлэгийн ёсыг баримтлагч Пиер Пауло Вергеро (Pier Paolo Vergerio (1370-1444)) анх орчуулсан бөгөөд тэрээр Сигисмунд (Sigismund) хаанд илгээсэн захидалдаа Арриен (Arrian)-ны эрдэм чадлыг Латины түүхчдээс хэтийдсэн хэмээн дурджээ. George Cary, *The Medieval Alexander* (Дундад Зууны үеийн Александр), (Cambridge, 1956), 238-9-р тал, 375-7-р тал.

Тууж (the Alexander Romance) буюу Сюүдө Келистенийз⁹ (Pseudo Callisthenes)¹⁰ гэх нэрээр танил болсон уг бүтээлийн тоолшгүй олон хувилбар (Үүнд илүү сайжруулсан хийгээд бүр дордуулсан хувилбарууд ч бий)-ын учир холбогдлоор үндсэндээ олон зууны уртад хэдэн арван мянган хүний дунд үлдсээр иржээ. Энэхүү гайхалтай зохиолыг бичсэн цаг хугацаа хийгээд эх сурвалжийн талаарх үзэл баримтлал ялгаатай байдаг ч энэ зохиолыг НТ 300 оны үед Александриа хотод грек-египетийн бичлэгийн зарчмаар бичжээ хэмээн өдгөө цагт энэ чиглэлийн судлалаар мэргэшсэн Меркелбах (Merkelbach) үзэж байна. Нэр нь үл мэдэгдэх зохиогчийн тулгуур болгон ашигласан хоёр сурвалж байх агаад нэг нь “Клейтарх (Cleitarhus)¹¹-ын уламжлал¹²-ыг баримтлан дээд хэмжээний уран яруу найруулгаар илүү өөдрөг дэврүүнээр бичсэн Александрын түүх; нөгөө нь НТӨ 1-р зуунд бичсэн *Александрын Туужийн Захидлууд* (Epistolary Romance of Alexander)-аас улбаатай захидлуудыг нэгтгэсэн цоморлог юм. Энэхүү цоморлогт өөрийн ээж Олимпиа, багш Аристотель хоёртоо Энэтхэг хийгээд Ертөнцийн хязгаарт зорчсон гайхалтай сайхан аяллынхаа тухай Александрын бичсэн нэлээд урт хоёр захидлыг оруулжээ. Меркелбахын хэлж байгаагаар тэдгээр захидал бол тухайн үеийн хэвшиж тогтсон ёс уламжлалыг бичмэл хэлбэрээр илэрхийлсэн явдал бөгөөд тэр мэт баримтууд уг зохиол¹³-ын хамгийн гайхамшигтай хийгээд сонирхолтой хэсгүүд болж чаджээ.

Александрын Туужийн Грек эх¹⁴ (Greek text)-ийг латин хэлнээ орчуулсан хоёр орчуулга бий. Нэгийг нь 4-р зууны эхээр Жюлиу Валериу¹⁵ (Julius Valerius), нөгөөг нь 10-р зуунд Наплын Лео (Leo of Naples)¹⁶ нар тус тус орчуулжээ. Эл хоёр орчуулга дундад зууны Европ¹⁷-д Александрын талаар бичсэн зохиолын гол сурвалж болох юм. Харин Азид ертөнцийн төгсгөлийн тухай зөгнөн бичсэн “*Александрын тухай Христийн Домог*” хэмээх зохиолын нөлөөгөөр дэлгэрсэн. Энэ нь Өрнөдөд төдийлөн танигдаагүй ч, Сири хувилбарыг нь олж саяхан хэвлүүлсэн гэдэг¹⁸. Энэхүү хувилбар уг туужийн сири хувилбарын гар бичмэлийн төгсгөлд

⁹ Грекийн нөлөө бүхий түүхч (НТӨ 360-327 он) бөгөөд Аугаа Александрыг Азийн улс орнуудаар аялахад түүнийг дагалдан явсан. Александрын Тууж (The Romance of Alexander)-ийг бичсэн нэр нь үл мэдэгдэх тэр зохиогчийг зарим тохиолдолд энэ хүнийг гэж үздэг. <https://en.wikipedia.org/wiki/Callisthenes>.

¹⁰ Энэхүү нэрийг гажуудуулсан. Грек эхийг анх нягтлан шүүсэн хүн нь түүний гар бичмэлүүдийн нэгийг ихэд үнэлж, “Тэрээр Сюүдө Келистенийс (Pseudo Callisthenes) гэх нэрийг номын хавтсанд тавьсан бөгөөд үүнд төдийлөн ач холбогдол өгсөнгүй” гэж тайлбарлажээ. A.R.Anderson, *Alexander's Gate, Gog and Magog, and the Inclosed Nations* (Александрын Хаалга, Гог ба Магог, болон Хаалттай Үндэстэн), (Cambridge, Mass., 1932), 30-р тал.

¹¹ Аугаа Александрын түүхчдийн нэг бөгөөд “Персийн Түүх”-ийн зохиогч, грекийн түүхч, он тооллын бичиг хөтлөгч, Колофоны Динон (Dionon)-ны хүү юм. <https://en.wikipedia.org/wiki/Cleitarhus>

¹² Cary. 356-р тал. (in an appendix by Professor D.J.A Ross (Профессор Д.Ж.А.Россын боловсруулсан хавсралтад бий)).

¹³ Reinhold Merkelbach. *Die Quellen des griechischen Alexanderromans* (Александрын Туужийн Грек эх), (Munich, 1954). 188-9-р тал.

¹⁴ https://en.wikipedia.org/wiki/Alexander_romance. Эндээс үзвэл Александрын Тууж (Alexander Romance)-ийн хамгийн эртний хувилбар грек хэлээр бичигдсэн хэмээсэн ч латин хэлнээ орчуулсан грек эхийг анхны уг эх (original) гэж үзэхэд нэн эргэлзээтэй байна. Мөн түүнчлэн англи хэлний “text” гэх үгийг монгол хэлнээ “бичвэр, текст, эх бичиг, эх зохиол” (*Oxford-Mongolian English-Mongolian dictionary*, 2004); “бичвэр, эх сурвалж, жинхэнэ бичвэр” (Чинбат Э. 2001) гэх мэтээр оноожээ. Дээр дурдсан бүхнийг үндэслэн эл үгийг “анхны уг эх”-ээс ялгахын тулд ийнхүү “грек эх” хэмээн орчуулав.

¹⁵ Грек Сюүдө Келистенийз (Pseudo-Callisthenes (Аугаа Александрын байгуулсан гавьяаг өгүүлсэн домгуудын цоморлиг))-ийн орчуулагч ажээ. https://en.wikipedia.org/wiki/Julius_Valerius_Alexander_Polemius

¹⁶ Өмнөд Италийн Кампания (Campania)-ийн нийслэл. “Наполи” (Napoli-итали), Неаполис (Neapolis-латин), “Наполес” (Nàpoles-испани), “Наплс” (Naples-франц) гэсэн нэршлүүдтэй. <https://en.wikipedia.org/wiki/Naples>; <http://www.thelatinlibrary.com/leo.html>.

¹⁷ Жюлиу Валериу (Julius Valerius), Наплийн Лео (Leo of Naples) нарын Дундад зууны үед шинээр үүсгэсэн үгнүүдийн тухай. Cary. 24-58-р тал.

¹⁸ E.A.Wallis Budge (хянан шүүж, орчуулав), *The History of Alexander, being the Syriac Version of the Pseudo-Callisthenes* (Александрын Түүх - Сюүдө Келистенийсийн сири хувилбар), (Cambridge, 1889), 144-58-р тал.

байх агаад үүнийг алдагдсан¹⁹ Палави эх (Pahlavi²⁰ text)²¹-д тулгуурлан VII зуун гарсан даруй тун удалгүй бичжээ. Уг *Домог*-ийн агуулгыг товч удиртгал гарчигт нэгтгэж, дараах байдлаар оруулав.

Македоны Филиппын хүү Александрын ертөнцийн хязгаарт хүрсэн хийгээд төмөр хаалга босгож “Умардын салхи” гэгддэг хүннүчүүдийг дотогш орж, дээрэм тонуул хийхээс сэргийлж тэрхүү хаалгаа хаасан зэрэг түүний байгуулсан гавьяаг Александриа хотод байдаг Хаадын нууц сан (архив)-д хадгалагдаж буй гар бичмэлүүдээс үзэж болно²².

Тэрээр эхлээд Өрнө зүгт дундаа жижиг арал бүхий, хүхрийн хүчилт далайн эрэг хүрээд, цааш Дорно зүг одов. Энэ талаар энд дэлгэрэнгүй өгүүлсүү.

Александр цэргүүдийн хамт зорьсон газраа буудаллаад хүхрийн хүчилт далай болон цэнгэг уст далайн заагаар өөдөө өгссөөр тэнгэрийн цонх (window of heaven)-оор наран ордог²³ тэр газар хүрэв. Наран бол Эзэн (Lord)-ийн зараал бөгөөд өдөр шөнийн аль ч цагт түүний ачаар Александр аяллаа цааш үргэлжлүүлсээр байлаа. Наран ургах зүгийн газар бол тэрхүү далайн чанадад байх агаад наран мандахын үест хүмүүс тэндээ хоргодож, түүнээс дайжин, далайд орж өөрсдийгөө далдлах²⁴ агаад энэ нь өөрсдийгөө нарны туяа (sun ray)-д түлэгдэхээс хамгаалдагтай холбоотой байж болох талтай. Наран өөдөө хөөрч²⁵, тэнгэр голлоод ирэхийн цагт уул нурууд амар тайвныг эс олно. Учир юу гэвэл хүмүүс хад асгад нь агуй оромж ухна. Хүн хийгээд шувууд (өөрсдийн нь дээр) наран ойртож ирэхийг харсан даруйдаа дайжин, мөнөөх агуйдаа нуугдаж хоргодно. Тэр үест хад чулуу гал адил халж, хагарч доош унана. Тэнд хүн, адгуусны алин болох нь үл ялгагдах амьтад байх агаад дээр нь чулуу унамагц тосож авна. Дараа нь тэрхүү наран тэнгэрийн цонхоор орохдоо, шууд доош бөхийн өөрийн Бүтээгч болсон Бурханыг хүндэтгэн мэхийн ёсолж, дараа нь бүхий л шөнийн турш тэнгэрээр аялж, дахин ургах хүртлээ их замыг туулах аж²⁶.

Дорно, Өрнө зүг хийсэн аяллынхаа дараа Александр умар зүг Армен (Armenia)-ийг дайран Кавказ (Caucasus)-д хүрэв. Нутгийн ардаас “Бидний харж буй тэр уулсын дунд ямар үндэстэн суудаг вэ?” хэмээн асуув. “Хүннүчүүд суудаг” гээд “Тэдний хаад нь Иафет (Japhet)²⁷ хааны

¹⁹ Зохиогч “a lost Pahlavi” гэж бичсэн. Хэдийгээр энд “өдгөө бидний үед уламжлагдаж ирээгүй” гэсэн санаа хадгалагдаж байгаа ч зохиогчийн сонгож бичсэн эл үгийн анхдугаар утгаар нь буулгав.

²⁰ Сонгодог Зороастриан болон Майникийн (<https://www.thefreedictionary.com/Manichean>) уран зохиол бичлэгт хэрэглэж байсан Дундад зууны үеийн перс хэл. <https://www.thefreedictionary.com/Pahlavi>

²¹ Budge (орчуулав), *The Alexander Book in Ethiopia* (Этиоп хувилбар дахь Александрын Тууж), (London, 1933), xviii-xix-р тал; Theodor Nöldeke, “Beiträge zur Geschichte des Alexanderromans (Александрын туужийн түүхэнд оруулсан хувь нэмэр)”, *Denkschriften der kaiserlichen Akademie der Wissenschaften, Philosophisch-historische Classe XXXVIII* (1890), Abhandlung V, 11-17-р тал.

²² Budge, *The History of Alexander* (Александрын Түүх), 144-р тал.

²³ Уг эхэд тэмдэглэснээр нь үгчлэн орчуулав. Утгачилбал, “наран шингэх”, “наран жаргах” гэсэн санааг илэрхийлж буй.

²⁴ Уг эхэд тэмдэглэснээр нь үгчлэн орчуулав. Угтаа бол “далайд орцгоов” гэсэн утгатай бололтой.

²⁵ Англи эхэд буй “rise” гэх үгийн тайлбарыг мөшгөн үзвэл “1. Байгаа байрнаасаа өөдөө чиглэх, өөдөө хөөрөх; 2. Босох, өндийх өөдлөх; 3. Нар, сар тэнгэрийн хаяанаас дээш гарч ирэх; 4.” буюу “хэвтээ тэнхлэгийн байранд байх юмс босоо байрлалд очих; доор байх зүйлс дээшээ, өөдөө болох” (*Oxford Advanced Learner's Dictionary*, 2010) гэсэн ерөнхий утгыг нь гол болгож, энд наран өөдөө нэлээд гарчихсан тэр цаг үеийн тухай өгүүлж буй тул ийн “хөөрөх” хэмээх үгийг сонгов. Энэ нь могой цаг буюу 09:40-11:40 хүртэлх цаг аж (Дулам.С. 2018b: 105-143).

²⁶ Ibid., 148-р тал, “Тэнгэрийн цонх (the window of heaven)”-д Нарны Эзэн Шамаш (Shamash the Sun God) энэ ертөнцөөр өдөр бүр аялахдаа дайрч өнгөрдөг дорно, өрнө байх хоёр үүдний талаарх эртний Вавилионы ойлголт өнөөг хүртэл уламжлагдаж ирсэн нь нэн гайхалтай. 227-р тал, 30-р зүүлтийг үзнэ үү.

²⁷ Зарим бичвэрт Жеифет (<https://en.wikipedia.org/wiki/Japheth>) гэсэн хувилбар байх хэдий ч “Иафет” (Ариун Библи, 2013: 10); “Эфээт” (Библи, 2015: 41); “Яапет” (буюу יַפֶּת (Yafet)) (*Bilingual Bible*, 1984: 10) (The Old Testament)) зэргийг харгалзан “Иафет” гэв.

хөвгүүд Гог (Gog), Магог (Magog)²⁸, Навал (Nawal) хаад²⁹ хэмээн хариулсан гэдэг. Тэрээр уулын хавцал³⁰-ыг хааж, тэдгээр үндэстнийг дотогш нэвтрүүлэхгүй хэмээн гуулин хаалга барих зарлиг буулгажээ.

Тэгээд Александр төмрөөр дарх хийдэг гурван мянга, гуулиар дарх хийдэг бас гурван мянган урлаачийг өөрөө удирдан тэнд аваачив. Тэд авчирсан төмөр, гуулиа буулгаад, нэг хэсэг нь яг нэг хүн шиг нэгэн зэрэг хольж нийлүүлж байхад нөгөө хэсэг нь шавар зуурч байлаа. Зуурсан шавраа авчирч, арван хоёр тохой урттай, найман тохой өргөнтэй хаалга хийлээ. Тэрээр хоёр уулын хооронд арван хоёр тохой урттай босго хийж, байц хаданд нь алхаар нүдэж тогтоогоод, гууль болон төмрөөр бэхлэв³¹.

Тэгээд Александр мөнөөх хаалган дээрээ нэгэн бичээсийг сийлүүлсэн бөгөөд уг бичээст Хүннүчүүд хожмын цагт халдаж орохыг урьдчилан хэлсэн байдаг. Үнэндээ ч тэрхүү халдлагуудын нэг нь 826 жилийн дараа болсон билээ³². Хэрэв Александрын тэр цаг үеийг мөшгөн үзвэл Хүннүчүүдийн халдлага үнэхээр 514 оны 10-р сарын 1-д болжээ. Энэ нь уг *Домог*-ийг зохиож аху цаг³³ Сабир (Sabir) хэмээгддэг Хүннүчүүд Кавказ орчмыг байлдан эзэлсэн цаг хугацаатай давхцаж байгаа юм.

Хаалгыг суурилуулж дуусгаад, Кавказын өмнө орших нутгийг бүхэлд нь захирч байсан Персийн хаан Тубарлах (Tubarlaq)-д Александр дайн зарлаж ялснаар өөрийн албатаа болгосон. Ром (Александрыг Ром хүн гэж хүндэтгэн үздэг) Персийнхтэй тэнцэхүйц тооны цэргийн хүчийг Александр аваачин, хүннүчүүдийн эсрэг мөнөөх хаалгаа хамгаалуулахаар үлдээж, өөрөө Персээс гарч одов. Аяллаас буцах замдаа Ерусалим (Jerusalem)-д очиж, тэндээсээ усан онгоцонд суун Александриа хотод хүрчээ. Тэрээр хааны мөнгөн суудлаа Христэд гэрээслэн үлдээгээд тэндээ тэнгэрт хальжээ³⁴.

Энэхүү *Христийн Домог* (Christian Legend)-ийг Сирийн яруу найрагч Саругийн Якоб (Jacob of Sarūgh, 521 онд насан эцэслэсэн)³⁵ шүлгийн хэмнэлээр бичсэн бөгөөд энэ хувилбар өдгөө ч хадгалаатай байна. Үүний дараа үргэлжилсэн үгийн бас нэгэн хувилбар гарсан агаад эл хувилбарт Хүннүчүүдийг Гог, Магог гэж үзсэний зэрэгцээ “Харанхуйн Орон”-оор аялсан аялал³⁶-ын талаар бичсэн Александрын Тууж (Alexander Romance)-аас нэлээдийг оруулжээ. Энэ хэлбэрээр “Домог (Legend)” зохиол нь хожмоо *Тууж (Romance)*-ийн Араб хувилбарт бараг бүхэлдээ багтсан ч харамсалтай нь үрэгдсэн. Гэсэн хэдий ч эл зохиолын этиоп орчуулгад хадгалагдан үлдсэн нь олзуурхууштай³⁷. Үүнээс хойш Александрын Туужийн араб хувилбар Оттоман (буюу Осман (Ottoman))-аас эхлэн Малай (Malay) хүртэл Исламын олон хэлэнд өөр хоорондоо ялгаатай хувилбарууд гарчээ³⁸. Гэвч эдгээр араб хувилбар гарахаас нэлээд

²⁸ Зарим бичвэрт “Мэигог” (https://en.wikipedia.org/wiki/Gog_and_Magog) гэж галигласан хэдий ч “Магог” (*Ариун Библи*, 2013); “Магог” (*Библи*, 2015); “Магог” (буюу מגוג (Magogu)) (*Bilingual Bible*, 1984: 10) (The Old Testament) зэргийг харгалзан “Магог” гэв.

²⁹ Budge, *The History of Alexander* (Александрын Түүх), 150-р тал.

³⁰ Александрын Хаалга босгосон анхны газар нь Тифлис (Tiflis), Владикавказ (Vladikavkaz) хоёрын дунд орших Төв Кавкази (the Central Caucasus)-д байдаг Дариалын хавцал (Darial Pass) юм.

³¹ Budge, *The History of Alexander Book* (Александрын Туужийн Түүх), 153-р тал. Александрын Туужийн Этиоп хувилбар (219-р хуудас болон 17-р зүүлтийг үзнэ үү.)-т “тэдгээр дархан том биетэй амьтдын арьсыг туламлан өвчиж, хөөрөг хийж, түүгээрээ гал гаргадаг...” гэж тэмдэглэжээ. Мөн Budge, *The Alexander Book*, 142-р тал. Тэдгээр тулман хөөргийн талаар уг *Домог*-ийн эх хувилбарт тэмдэглэгдсэн байх учиртай. Кораны хувилбар (the Koranic version) (20-р тал) болон дээр өгүүлсэн Эргэнэ Хунгийн Домог (the Ergene Qun legend) (222-3-р тал)-ийг үзнэ үү.

³² Budge, *The History of Alexander* (Александрын Түүх), 154-р тал.

³³ Nöldeke, 31-р тал. Армен болон Азийн бага үндэстэн рүү хийсэн Сабырийн халдлагын талаар, Arthur Christensen, *L'Iran sous les Sassanides* (Сассинидын эзэнт гүрний үеийн Иран) (Copenhagen and Paris, 1936), 346-7-р талыг үзнэ үү.

³⁴ Budge, *The History of Alexander* (Александрын Түүх), 156-8-р тал.

³⁵ Саругийн Якоб (Jacob of Sarūgh)-ын тухай. Nöldeke, 30-2-р тал.

³⁶ 224-р талыг үзнэ үү.

³⁷ Nöldeke, 32-р тал.

³⁸ Budge, *The Alexander Book* (Александрын Ном), xx-xxii-р тал.

хугацааны өмнө *Александрын тухай Христийн Домог* (Christian Legend concerning Alexander) арабын ертөнцөд орж ирэх нөхцөл бүрдэж, Несторын номлогчдоор дамжин Зүүн Хойд Азийн Түрэг, Монгол хоёр үндэстний ёс уламжлалд шингэжээ.

Коран³⁹ (The Quran) судар⁴⁰-т Дул Харнайн⁴¹ (Dhu'l-Qarnain) буюу Хоёр эвэрт (the Two-horned)⁴² гэх нэрээр алдаршсан Александрын аяллыг дараах байдлаар бичжээ.

Тэрээр наран хүүшлэх⁴³-ийн үест тэнд хүрч, тэрхүү наран балчигтай намгийн эх ундарга руу шингэх⁴⁴-ийг нь олж үзэв. Цааш замдаа гарч, наран ургах газар хүрээд, тэндхийн иргэдийн дээр наран гарахыг олж үзэв. Тэдгээр иргэнд нарнаас халхлах хэрэгсэл өгсөнгүй... Цааш явж, хоёр уулын хоорондох хавцлын аманд хүрч ирээд, үл ойлгогдох хэлээр хэлэлцэх хэдэн иргэнтэй бэлд нь таарав. Тэд “Дулхайрнай (O Dhoulharnain), үнэндээ Гог, Магог нар энэ газрыг талхалсан. Бид танд алба барьсу. Та хамгаалалтын хэрэм босгож өгтүгэй” хэмээжээ. Тэрээр хариуд нь “Та нар алба гувчуур гэхээс илүү миний Эзэн (Lord) намайг хүчирхэгжүүлэх тэр их сүр хүчийг надад өгтүгэй. Бас надад хүч хавсрагтун. Тэгвэл би та бүхэнд тэр хаалгыг барьж өгсү” хэмээв. Мөн тэрээр “хоёр уулын хоорондох хавцлыг хаах хэмжээний төмөр хавтанцруудыг авчирч өгтүгэй. Галыг улайдтал нь тулман хөөргөөрөө сайтар хөөрөгдөгтүн. Хайлуулсан гуулиа надад авчирсугай. Би тэр хаалтан дээр гоожуулсу. Ингэх аваас Гог, Магог нар энэ хаалгыг давж чадахгүй, доогуур нь газар малтаад ч нэвтэрч чадахгүй” хэмээжээ⁴⁵.

Наран ургах зүгийн газрын тухай эл үлгэр Саманид (Sāmānid)-ын удирдагч Исмаил ибн Ахмад (Ismā'il ibn Ahmad)-ын үед амьдарч асан Абу ал-Аббас Иса бин Мухамад ал-Марваз (Abu'l- 'Abbās 'Isā b. Muhammad al-Marwazī)-ын даалгавраар XIII зууны үеийн газарзүйч, Яахут (Yāqūt)-ын бичсэн “задын чулуу”⁴⁶-ны уг гарвалийн тухай өгүүлсэн Түрэгийн нэгэн домогт гардаг.

³⁹ *Quran* болон *Koran* гэсэн хоёр хэлбэрээр бичдэг хэдий ч зохиогчийн хэрэглэсэн “Koran” гэсэн хувилбарыг үлдээж, галиглан оруулав

⁴⁰ *The Holly Quran*. Abdullah Yusuf Ali орчуулав. 18. Al-Kahf – The Cave. Section 11, (*The Holly Quran*, 2000) болон <https://en.wikipedia.org/wiki/Quran> -аас дэлгэрэнгүйг үзнэ үү.

⁴¹ Монголчуудын дунд Сулхарнай гэх нэрээр алдаршсан бөгөөд “Арабын Цүл харнай буюу Дул харнай хэмээх үг монгол хэлэнд сунжраад Сулхарнай болжээ. Утга нь хоёр эвэрт хэмээсэн үг. Араб нар Македоны Александрыг чингэж нэрлэдэг байжээ” (Дамдинсүрэн.Ц, 2017: 180–192).

⁴² Христийн Домог (Christian Legend)-т Бурхан өөрийнх нь толгойг эвэртэй болгосон, хийгээд түүгээрээ энэ ертөнцийн хаант улсуудыг эзэлж болох тухай Александр өгүүлсэн байдаг. Budge, *The History of Alexander* (Александрын Түүх), 146-р талыг үзнэ үү. Мөн түүний зүүдэнд Бурхан гарч ирээд, “Би чиний толгойн дээр эвэрнүүд хийсэн. Чи тэдгээр эврээрээ энэ дэлхий дээрх хаант улсуудыг эзлэгтүн” хэмээн хэлсэн тухай тэмдэглэсэн бөгөөд 156-р талыг бас үзнэ үү. Budge, *The Alexander Book* (Александрын Тууж) 25-р тал, 1-р зүүлтэд тэмдэглэгдсэн “Хоёр Эвэрт” гэх нэр бол “Эртний Египетээс уг гарвалтай байж болох бөгөөд... Либиегийн Аммон Бурхан (God Ammon (Amen-Rā) of Liby)-д өгсөн учраас Александр тэрхүү нэрийг авчээ”. Дул Харнай (Dhu'l-Qarnain)-н талаарх Исламын олон тайлбарыг сонирхож байвал Emilio García Gómez, (хянан шүүж, орчуулав) *Un texto árabe occidental de la leyenda de Alejandro* (Александрын домгийн талаарх баруун Араб эх), (Madrid, 1920), xlviii-р талыг үзнэ үү.

⁴³ “Наран хүүшлэх цаг” гэдэг нь бичин цаг буюу 15:40-17:40 хүртэлх цаг аж (Дулам.С, 2018b: 105–143).

⁴⁴ “Наран шингэх цаг” гэдэг нь 17:40-19:40 хүртэлх тахиа цаг аж (Дулам С. 2018b: 105–143).

⁴⁵ XVIII. 85-9. Rodwell's translation (Родвеллийн орчуулга) (Everyman's Library), 188-р тал. Мөн R.A. Nicholson-ы орчуулсан *A Literary History of the Arabs* (Арабын Утга зохиолын Түүх) (London, 1907), 18-р талд байгаа Мухамадийн даалгавраар шүлэг бичдэг Hassān ibn Thābit-ын бичсэн шадуудыг үзнэ үү. Мөн Anderson эш татсан. 29-р тал, 1-р зүүлтийг үзнэ үү.

⁴⁶ 1. Монголчууд гурвалжин гилбэр дүрстэй, эсвэл өндгөлжин хэлбэртэй, улаан хүрэн, улаавтар шар, хар өнгөтэй том нь нударган чинээ пахиурлаг чулууг «задын чулуу» гэдэг байжээ (Болдбаатар Ю. 2008: 32); 2. Шинэ чулуун зэвсгийн үед холбогдуулж үздэг бүх талаас нь уртааш ялтас цуулж авдаг асан нэгэн зүйл шовх үлдцийг монголчууд «задын чулуу» хэмээн нэрлэж иржээ (Гонгоржав Г. 2005: 17).

Огуз (Oghuz) ханхүү⁴⁷ “өөрийн нэг өвөг нь эцэгтэйгээ зөрөн байж зүүнш зорчиж, нэгэн газар хүрч очоод нутгийн ардаас “Нэгэн уул хаасны учир энэ газраас цааш явах арга үгүй” гэж сонссон” тухайгаа Абу ал-Аббас (Abu'l- ‘Abbās)-ын хүмүүс⁴⁸-т нэгэнтээ хүүрнэсэн байдаг. Тэдний хэлснээр “тэрхүү уулын цаанаас наран мандах агаад тэр нь газар дэлхийтэй ойр тул, халуу шатахгүй газар гэж үгүй” аж. Харин ханхүүгийн өвөг “Тэнд хүн, амьтан байдаг уу?” хэмээн асуухад “Байдаг” гэж тэд хариулжээ. Тэрээр мөн “Та нарын хэлсэн шиг тийм нөхцөлд тэд яаж амь зууж, аж төрдөг вэ” гэхэд “Газрын доогуур хонгил, уулын гүнд агуй байх агаад наран мандахын үест хүмүүс тэнд бүгж, шингэх⁴⁹-ийн цагт тэндээсээ гарч ирдэг. Харин амьтад чулуу авч зогсдог нь туйлын хачирхалтай агаад үүний учрыг мэдэх чин хүслийг төрүүлжээ. Тэр амьтад бүгд нэг нэг чулуу аваад, амандаа зууж, толгойгоо тэнгэр өөд өлийлгөн, өөрсдийгөө сүүдэрлүүлнэ. Удалгүй нэг хэсэг үүл хуралдаж, тэр амьтдыг нарнаас халхалдаг” гэж хариулжээ. Түрэгийн ханхүүгийн өвөг мөнөөх улсад нэвтэрч, сонссон бүхэн нь үнэн болохыг олж үзэв. Тэрээр дагалдан яваа хүмүүсийн хамт мөнөөх амьтад руу дайрч, чулуунуудыг нь авч цуглуулан, даах хэмжээгээр өөрийн улс руу зөөн аваачиж, тэр цагаас эхлэн өнөөг хүртэл хадгалсаар ирсэн бөгөөд цас бороо оруулахад хэрэглэж байжээ⁵⁰.

4-р Инносент (Innocent IV)-ын томилгоогоор Монголд элчин сайдаар суусан Жон де Плано Карпини (John de Plano Carpini)-ийн “Монголчуудын түүх (Ystoria Mongalorum)”⁵¹ номдоо бичсэнчлэн, тэрхүү “наран ургах зүгийн газар” гэдэг нь Чингис хааны байлдан дагуулж асан улсуудын нэг юм. Энэ улсын нэрийг Жорж Д.Пэинтер (George D.Painter)-ийн саяхан нягтлан шүүж, орчуулсан “Татар”⁵²-чуудын Харилцаа (The Tartar Relation)” нэртэй зохиол болон Винландын Газрын зураг (Vinland Map) гэсэн ботид дараах байдлаар тэмдэглэжээ.

Чингис (Chingis)⁵³ цэргүүдийн хамтаар дүрвэж, баруунтаа орших уулсаас умарш чиглэн одов. Бүтэн гурван сарын турш тасралтгүй цөлөөр явсны эцэст цэргүүдэд хоол хүнс хомстсон учир арван цэрэг тутмын нэгийг идэх зарлиг буулгажээ. Тэд ийнхүү гурван сарын турш явсаар Нара иргэн (Naraygen) буюу Нарны хүмүүс (Nara гэдэг нь “Нарны Татарчууд”, харин Irgen гэдэг нь “Иргэн” гэсэн утгатай) гэсэн нэртэй газар сүндэрлэх уулсын дунд хүрэлцэн ирлээ. Тэр газар хүрээд нэг ч хүнтэй таарсангүйд ихэд цочирдов. Гэтэл удаж төдөлгүй эхнэртэйгээ яваа нутгийн нэгэн эртэй таарч эл нутгийн иргэд хааш одсон талаар асуун шалгааж, олон зүйлийг мэдэж авав. Тэндхийн иргэд ууланд нүхэн гэр (буюу өрх)⁵⁴ барин суух агаад олзлогдсон эрээр тэрхүү хоригдол эмийг харгалзуулан, “тэндээс гарч бослого тэмцэлд оролцох санаа

⁴⁷ Огуз nāme/nāma буюу Огуз хааны домогт ийн өгүүлдэг аж.

⁴⁸ Угтаа бол “мэдээлэгчид” юм.

⁴⁹ Наран шингэх цаг гэдэг нь тахиа цаг буюу 17:40-19:40 бололтой (Дулам С. 2018b: 105–143). Харин “наран шингэхийн урьдах цаг” гэх мэт хэллэг монголын уран зохиолуудад нэлээн дурдагдсаны нэгэн жишээ бол Монголын нууц товчоо (Igor de Rachewiltz. 1972, 2034, 4038, 5537, 6720, 8933, 10729, 11650-р зүйлүүд) юм.

⁵⁰ J.A.Boyle, “Turkish and Mongol Shamanism in the Middle Ages (Дундад зууны үеийн түрэг, монгол бөө мөргөл)”, *Folklore* 83, 177-93 (187-8)-р тал.

⁵¹ *The Mongol Mission* (Монгол Элч), (London, 1955), 3-84-р тал. Хамгийн сүүлийн үеийн, хамгийн бүрэн гүйцэд гэж хэлж болохуйц орчуулга бөгөөд Кристофер Давсон (Christopher Dawson)-ы Станбруккийн католик сүм (Stanbrook Abbey)-ийн гэлэнмаа хянан нягталжээ.

⁵² “Тартар” буюу “Татар” гэх нэрийн тухай дэлгэрэнгүйг (Монголын эртний түүх. 2017: 25–63) -ээс үзнэ үү.

⁵³ Энд зохиогч Чингис (Chingis) хэмээн бичиж, харин дараа нь Чингис хан (Chingis Khan) гэж тэмдэглэснийг уг эхийг хаалтанд оруулж, тэр хэвээр нь үлдээв.

⁵⁴ “Монгол гэрийн сүлд гэгддэг “өрх” хэмээх үгийн гарал нь “erü-ke” буюу “erü-” (эрэ-, малта-) хэмээх үйл үгийн язгуураас үүссэн “малтмал”, “малтмал гэр”, “малтмал нүхэн гэр” гэсэн утга бүхий “erüke” гэдэг үг болох талаар манай хэл шинжлэлчид, үгийн гарал судлаачид [Б.Ринчин нар] нэгэнт тогтоожээ” (Дулам С. 2018a: 213–217).

бий” эсэхийг асуулгахаар илгээж буй нь тэр аж. Тэр эрийг буцах замд наран мандах дуунаар татарчууд зогсож байсан газраа түрүүлгээ харан үхэтхийн унаж, олон хүн тэр дороо амьсгал хурааж байлаа. Нутгийн уугуул иргэд дайснуудтай тулгарч, шөнө дүлээр тэдэн рүү дайрч, маш олон Татар иргэнийг хороов. Чингис хан (Chingis Khan) амьд үлдэгсэдтэйгээ дутаахдаа тэрхүү эхнэрийг нь хамт авч одов.

Тэдгээр Татар иргэн өөрсдөө христийн шашны сахилтан (friars)⁵⁵ нарт хэлсэн учраас тэр эм эцэстээ удаан хугацаагаар тэдэнтэй үлдэж, өмнө өгүүлж байсан улс энэ ертөнцийн хязгаарт бий, түүнээс цааш (хуурай)⁵⁶ газар үгүй, зөвхөн их далай бий хэмээн эргэлзэх зүйлгүйгээр итгэл дүүрэн хэллээ. Наран ихэд ойр тул мандах тэр агшинд нэн ялангуяа зуны улиралд тэр мэт байгалийн болоод өөр бусад асар их хүчтэй дуу, нүжигнээн тийн сонсогддог ажээ. Энэ нь наран, тэнгэр хоёрын эсрэгцлээс үүдэлтэй бөгөөд наран нь нарны замаар дайран өмнөш эргэх хүртэлх тэр мөчид хэн ч байсан гадаа ил задгай газар байхын арга үгүй тул түүнээс болоод шууд амиа алдаж мэдэх, эсвээс цахилгаанд цохиулсан мэт гэмтэж бэртэх аюултай. Тиймээс иргэд уулын агуй дотроо том хэнгэрэг хийгээд бусад зэмсэг дэлдэж, гарах дуу чимээгээр нь нарны тэр их дууг дардаг аж. Энэ нутагт тэгш тал зонхилох бөгөөд хөрс нь үржил шим сайтай. Уулс нь хөндөлдөн тогтсон ч төдийлөн сүрлэг том биш⁵⁷.

Карпини бээр маш товч бичсэнээс төдийлөн зөрүүгүй энэхүү хувилбарт эл үлгэрийг Монголчууд үе дамжуулан хэлж ирсэн бөгөөд үүнийг Нараиргэн (Narayngen (буюу наран ургах зүгийн газарт өгсөн “Нарны иргэд” гэсэн нэр)) гэх Монгол нэрээр нь баталж болохыг онцгойлон дурджээ. Хэд хэдэн судлаач Япон (Jih-pên kuo (буюу “Нарны эх болсон улс (country of the source of the sun)”)”⁵⁸) улсад өгсөн Хятад-Япон нэрийг монгол хэлнээ дүйцүүлсэн Нараиргэн (буюу Narayngen) гэх нэрийг сонирхон судалж ирсэн. Энэ мэт тайлбар нь зөвхөн Карпинийн өгүүлсэн үлгэрийн хувьд үнэмшилтэй бөгөөд илүү бүрэн гэж хэлэхүйц энэхүү хувилбарыг монгол эхээс нэлээд холдсон гэж үздэг. Гэвч “нарны иргэд (people of the sun)” бол “задын чулуу”-ны уг гарвалын талаар өгүүлдэг *Христийн домог*, Коран болон 10-р зууны үеийн Огузын домогт дүрслэгддэг агуйд амьдардаг ер бусын шидтэй, балар эртний хүмүүс хэмээн үзжээ. Үүний баталгаа Методийн *Илчлэлүүд*⁵⁹ (the Revelations of Methodius) гэх нэрээр дэлгэрсэн, ертөнцийн төгсгөлийг зөгнөн бичсэн зохиолд бий. Уг зохиолыг IV Константин (Constantine IV (668-685))-ын хаанчлалын төгсгөл үеэр Сирид бичиж дуусгажээ. Энэ нь хожмоо латин хэлнээ орчуулагдаж, Дундад зууны турш Европын соёлд томоохон байр суурийг эзэлж байсан ч өнөө цагт тэр нь суларсан⁶⁰. Эл зохиолд Александрыг “Нарны Орон

⁵⁵ Энэ нь XII-XIII зууны үед анх бий болсон бөгөөд ард түмний дунд байж, өглөг буян, хандив тусламжийн ачаар шашин номын үйл хэргээ явуулдаг, сүмийн ахан дүүсийн холбоогоор нэгдсэн лам нар <https://en.wikipedia.org/wiki/Friar>

⁵⁶ Англи хэлний “land”, монгол хэлний “газар” хэмээх үгнүүд олон утгыг илэрхийлдэг тул илүү тодорхой болгох үүднээс ийнхүү нэмж оруулав.

⁵⁷ R.A.Skelton, Thomas E.Marston, George D.Painter, *The Vinland Map and the Tatar Relation* (Винландын Газрын зураг ба Татарчуудын Харилцаа), (New Haven, London, 1965), 64-65-р тал. Карпинигийн зохиолд байхгүй хэлц хэллэг, өгүүлбэрийг Пэинтер үсгийн налуу хэлбэрээр тэмдэглэснийг эс оруулав.

⁵⁸ B.B.Szczesniak, “Notes and Remarks on the Newly Discovered Tartar Relation and the Vinland Map (Шинээр олдсон Татарын Харилцаа ба Винландын Газрын зургийн талаарх тайлбарууд)” *Journal of the American Oriental Society* 86, 373-6 (376)-р тал; Denis Sinor, “Mongol and Turkic Words in the Latin Version of John of Plano Carpini’s Journey to the Mongols (1245-1247)”, in *Mongolian studies*, L.Ligeti хянан шүүв. (Amsterdam, 1970), 537-51 (544-5)-р тал.

⁵⁹ Англи Библи сударт буй Revelation-ийг 1. “Илчлэл” (*Ариун Библи*, 2013: 1390); 2. “Есүс Христийн харуулсан үзэгдэл” (*Библи*. 2015: 1558); 3. “Илчлэлт (буюу ヨハネの黙示録)” (*Bilingual Bible*, 1984: 526) (The New Testament)) хэмээн орчуулжээ. Толь бичиг дэх монгол орчуулгыг шүүвэл: 1. “1. Илрүүлэх, илчлэх; 2. Илчлэх өдрүүд (шашин суртахуунд)” (*Oxford-Monsudar English-Mongolian dictionary*. 2004); 2. “Нээлт, илрүүлэлт, илчлэл” (Чинбат.Э, 2001) гэжээ. Харин уг үгийг англи хэлнээ “1. Хүмүүст нууц, далд байсан зүйлийг ойлгуулах; 2. Нууц зүйлийг хүмүүст ойлгуулах үйл; 3. Бурхнаас илгээсэн дохио (тэмдэг), мэдээлэл гэж ойлгогдох зүйл” (*Oxford Advanced Learner’s Dictionary*. 2010) гэж тайлбарлажээ. Энэ бүхнээс үүдэн “Илчлэл” гэсэн үгийг сонгов.

⁶⁰ Anderson, 44-5-р тал. Энэ зохиолыг Сюдо-Методиус (Pseudo-Methodius) гэж үзсэний учир нь Гэгээн Метод (St.Methodius)-ийг гар бичмэлүүдэд үргэлж багтаадаг бөгөөд тэрээр 4-р зууны эхэн үеийн мартер

гэгдэх далай”⁶¹ хүртэл аялсан гэж бичжээ. Зохиогч тэндхийн хүмүүсийг Гог, Магогийн иргэд гэж будилуулах эс бөгөөс тэднийг хэмээн үзэж, Иафетын үр хойчис гэж бичсэн бөгөөд зохиолынхоо эхэн хэсэгт “тэр Усан галав”⁶² (the Flood)-аас хойш 100 жилийн дараа төрсөн, Ноа⁶³ (Noah)-ийн хүү Ионитус (Ionitus)-ыг эцэг нь дорно зүг илгээснээр, Ионит наран ургах газар⁶⁴ байдаг Нарны Орон хэмээн нэрлэгддэг мөнөөх далайн эрэгт хүрэлцэн очив” гэжээ. Тиймээс “Нарны Орон” буюу “Нарны Иргэд” гэх хэллэгийг лавтайя 7-р зуун⁶⁵-аас хэрэглэж эхэлсэн бөгөөд үнэн хэрэгтээ энэ нь Несторын номлогчдоор дамжин Алс Дорнодод хүрсэн *Христийн Домог* (Christian Legend)-ийн нэгэн хувилбарт тэмдэглэгдэн үлджээ.

Александр Гог, Магогийн иргэдийг нэвтрүүлэхгүй гэж уулын хавцлыг хааж, төмөр, гуулиар хаалга хийсэн тухай тэмдэглэсэн Коран хувилбарын талаар бид өмнө нь сонсож байсан удаатай. Уг үлгэр Монгол үндэстний үүсэн бүрэлдсэн хийгээд дахин хүчийг олсон тухай Эргэнэ Хун⁶⁶ (Ergene Qun)-ийн домогт гардаг хэсгүүдээс нэгээхнийг эргэн сануулдаг. Энэхүү үлгэрийг 14-р зууны үеийн Персийн түүхч Рашид ал-Дин (Rashīd al-Dīn)⁶⁷ маш дэлгэрэнгүй өгүүлжээ. Түүний цаг үеэс даруй 2000 орчим жилийн тэртээ Монголчууд бараг бүгд хөрш зэргэлдээх овог аймгуудтай хийсэн тулаанд ялагдаж, ердөө хоёр эр л эхнэрийн хамт амь гарч, “Эргэнэ Хун (буюу ‘Steep Cliff’)” хэмээн нэрлэгддэг, сүрлэг сайхан уул, шигүү ургасан ой модоор битүү хүрээлэгдсэн, үржил шимт нэгэн сайхан хөндийд толгой хоргодон амь зуух болжээ. Цаг хугацаа өнгөрсөөр тэдний үр хойчис өсөж үржин, мөнөөх хөндийдөө багталцахгүй болтлоо дүүрч, дараа нь тэндээсээ гарч шинэ нутагт бууя хэмээн цугаар ярилцаж тогтов. Тэрхүү уулсын нэгээхэн хэсэгт төмрийн уурхай байх агаад сайн чанарын мод, модны нүүрсийг цуглуулаад, уурхай байрлах тэр эгц эргэцгийн бэлд аваачиж хураав. Дараа нь далан үхэр, адуу нядалж, арьс ширээр нь мөн тооны дархны тулман хөөргийг хосоор нь хийв. Хураасан мод, модны нүүрсэндээ гал өрдөн, далан хос хөөргөө нэгэн зэрэг үлээж, тэр их галд төмрийн хүдрээ хайлуулж, тэрхүү халуун хайлмалаа өөрсдийн бэлдсэн шуудуугаар уруудуулан өргөн уудам тал хүртэл урсгаж нүхэн хоолой гаргав.

байлаа. Андерсоны тайлбар (Anderson remarks) (49-р тал)-г “The influence of Pseudo-Methodius (Сюдө-Методын Нөлөө)” нь гайхамшигтай агаад ... Сакур (Sackur)-ын дурдсанчлан (магадгүй) Дундад зууны үед *Сюдө-Метод* (Pseudo-Methodius)-ын нөлөө Канон (Canon) болон гэгээн эцэг (the church fathers)-үүдийн дараа хоёрт орж байжээ. Үүний шалтгаан нь дундад зууны дунд хагасаас хойш Монголчуудын байлдан дагуулал, Веннийн хана хүртэл Түрэгүүдийн өрнө зүг хийсэн довтолгоо гээд христийн ертөнцөд аз сорьсон, таагүй үйл явдлууд ар араасаа тохиолдож байлаа. Энэ бүх зайлшгүй шаардлага хийгээд хамгийн хүнд хэцүү цаг үеийн талаар *Сюдө-Методиус* (Pseudo-Methodius)-д тэмдэглэгдсэн бөгөөд тэр үед Христийн ертөнцөд Гог, Магог болон Христийн шашны эсрэг асар их хүчийг ялан дийлнэ гэдэг итгэл, найдвараас өөр зүйл байсангүй.

⁶¹ Anderson, 46-р тал; Ernst Sackur, *Sibyllinische Texte und Forschungen* (Сибиллин эх ба судалгаа) (Halle, 1898), 72-р тал.

⁶² Ариун Бичээс Нийгэмлэгээс “Зөвлөх багийн санал ёсоор шинэ хянан засварласан стандарт хувилбар (NRSV)-ыг баримжаа болгон (Ариун Библи. 2013)” орчуулсан “Ариун Библи”-д “Их Үер” гэж орчуулсан (Ариун Библи. 2013: 7). Харин Монголын Библийн Нийгэмлэгээс “«Хуучин гэрээ»-ний номуудыг орчуулахдаа МЭ 500-1000 оны үед Масоретуудын хэрэглэж байсан еврей хэлний текстүүдийг үндэс болгон (Библи. 2015: 10)” орчуулсан “Библи”-д ийнхүү “Усан галав” (Библи. 2015: 39) гэснийг дагав. Учир нь “«Усан галав» гэдэг нь “Ертөнц тогтох буюу сөнөх нь усан галавт тохионо” (Монгол хэлний их тайлбар толь)” гэсэн тайлбартай холбогдуулан үзэв.

⁶³ Noah-г хэрхэн галигласныг шүүн үзэхүл 1. “Ноа” (Ариун Библи. 2013); 2. “Нуах” (Ариун Библи. 2013); 3. “Ноа (буюу / ㄴ /)” (Bilingual Bible, 1984) гэжээ. Нийтэд тархсан жишгийг харгалзан эл орчуулгад “Ноа” гэж галиглав.

⁶⁴ Sackur, 63-4-р тал.

⁶⁵ Энэ нь маш эртнийх байж болох юм. Сакурын тайлбар (Sackur remarks), (16-р тал)-аар бол Нарны Орон (the Land of the Sun) гэдэг нь ертөнцийн хязгаарт байх Наран Ургахын Вавилоны уулын нэгийг бидэнд сануулах бөгөөд түүгээр Нарны Бурхан Шамаш (Shamash, the Sun God) тэнгэрээр хийх аяллынхаа эхэнд Зүүн Үүд (the Eastern Gate)-ээр дайрч явдаг аж. L.W.King, *Babylonian Religion and Mythology* (Вавилоны Шашин шүтлэг хийгээд Домог зүй), (London, 1899), 32-3-р тал.

⁶⁶ Эргүнэ гүнгийн домог ч гэж бас хэлдэг ажээ https://mn.wikipedia.org/wiki/эргүнэ_хунгийн_домог.

⁶⁷ *Sbornik Letoposei* (Судрын Чуулган), I/I, A.A.Khetagurov орчуулав. (Moscow-Leningrad, 1951), 153-4-р тал.

Тэдний соёлд уламжлагдаж ирсний адил, Эргэнэ Хунгийн домгийг монголчууд өөрсдийн Түрэг (Turkish⁶⁸) угсаатны өвөг дээдсээс уламжлан авч дамжуулсан бололтой. Хятадын түүхчдийн нэрлэснээр эртний Түрэгүүд болохын хувьд Хөх Түрэг (T'u-chüeh)-ийн уламжлалд уулын агуйн талаар хүүрнэх бөгөөд тэдний анхны өвөг болох бөртэ чоно гэргийн хамтаар дайснаасаа дутааж, оромж хайн тэр агуйд хүрэлцэн ирсэн тухай өгүүлдэг. Тэр агуйгаар дамжин тэд хэдэн зуун мод (li) талбай эзлэх, өвс ногоо жигдэрсэн тал сайхан газар одож, тэндээ хэдэн үеэрээ нутаглаж, эцэс сүүлдээ Алтайн өвөр биед очиж суурьшив⁶⁹.

Эл хоёр хувилбараас *Домог*-т эцэстээ Гог, Магогийн иргэд болох Хүннү, Түрэг болон Монголчууд уулын мухраас гарч гадаад ертөнцөд хөл тавина хэмээн урьдчилан хэлснийг мэдэж болно. Гог, Магог гэх нэрсийн талаарх түүх тун сонирхолтой. Эхлэл⁷⁰ (Genesis)⁷¹ бүлэгт Магогийг Иафетын хөвгүүдийн нэг гэж дурдсан агаад тэрээр Зүүн болон Хойд Арменитай харилцаатай байдаг Кавказын өмнө орших нутагтай холбоотой учир эл нэрийг авчээ. Ээкиэл⁷² (Ezekiel)⁷³-д Гог (олон хүн түүнийг дагалдаж) морь унаж, “бүлэг иргэд, хүчирхэг цэргээ дагуулан” Магогийн газрын хойно байх нутгаасаа гарч энэ нутагт ирсэн тухай өгүүлдэг. Бид Гогийн талаар анх удаа сонсож байгаа нь энэ бөгөөд Магог Кавказын өмнөд хэсгийн биш өөрийн хаант улсын эзэн суув. Үнэн хэрэгтээ Гогийн байлдан дагууллыг киммерчүүд (Cimmerians⁷⁴(Тэд тал нутгаас Дариал (Darial)-ын хавцлаар дамжин өмнө зүгт ирж, тэндээ 8-р зууны сүүл⁷⁵ хүртэл суурьшсан))-ийн байлдан дагууллын үргэлжлэл хэмээн Ээкиэлд тодорхойлсон байдаг. Эцэст нь, 1000 жилийн дараа Сатаныг шоронгоос суллагдахад түүнийг зараалаар ирэх хүмүүс бол Гог, Магог нар юм хэмээн Илчлэл (Revelation)⁷⁶ -д бичсэн нь бий. Хожим ийм явдал үнэхээр тохиолдож, тэднийг *Александрын тухай Христийн Домог*-т өгүүлдэг Хүннү, Түрэг, Монгол зэрэг нүүдэлчин үндэстэн гэж байсан тухай, мөн түүнчлэн Гог, Магогийг өөрөөр тодорхойлохын тулд анхандаа Төв Кавказид байсан Александрын хаалга босгосон газрыг умарш эсвэл зүүнш байдаг мэтээр үргэлжид ийнхүү байршлыг нь өөр хооронд нь зөрүүтэйгээр бичдэг байлаа⁷⁷.

Одоо *Александрын Тууж*-аас *Христийн Домог*-т нэвтэрсэн хэмээн бидний үзэж буй “Харанхуйн Орон”-оор хийсэн Александрын аяллын хэсэг рүү орё. Үнэндээ тэрхүү Харанхуйн Орон гэх газар бол домгийн газар биш бөгөөд эл нэрийг дундад зууны үед (магадгүй түүнээс ч өмнө байж болох юм) одоогийн Зөвлөлт Холбоот Улс⁷⁸-ын хойно буюу Хойд туйлын наахна орших бүс нутагт өгчээ. Энэ газар хүрэлцэн ирээд Александр дагалдан яваа хүмүүстээ хандан хөхүүл дудран⁷⁹-г нь үлдээгээд дудрай⁸⁰-г авчрах зарлиг буулгав. Учир нь ямар ч амьтан нялх

⁶⁸ Орчин цагт Түрэг судлал (Turkic studies or Turkology), Турк судлал (Turkish studies) хоёр нь судалгааны хамрах хүрээгээрээ ялгаатай тул тусдаа, бие даасан салбар болтлоо хөгжиж, ийнхүү ялгаатай нэрлэгдэж хэвшжээ. Харин эл өгүүллийг бичиж хэвлүүлж байсан цаг үед ингэж ялгамжтайгаар авч үздэггүй байсан бололтой. Тиймээс зохиогчийн хэрэглэсэн “Turkish” гэх нэрийг түүний агуулгыг нь харгалзан “Түрэг”, мөн хойно дурдах “Turks” гэх нэрийг “Түрэгүүд” хэмээн тус тус орчуулав.

⁶⁹ Liu Mau-tsai, *Die chinesischen Nachrichten zur Geschichte der Ost-Türken (T'u-küe)* (Зүүн Түрэгийн талаарх хятад баримт), (Wiesbaden, 1958), I, 40.

⁷⁰ Библи судрын монгол орчуулгуудад ийн орчуулжээ (*Ариун Библи*. 2013: 7), (*Библи*. 2015: 1048).

⁷¹ x.2. Anderson 7-р тал.

⁷² <https://en.wikipedia.org/wiki/Ezekiel>-д “Изэкиэл”, Библийн монгол орчуулгуудад “Езекиел” (*Ариун Библи*. 2013: 933), “Яахизхийл” (*Библи*. 2015: 1048), Библийн япон орчуулгад “Ээкиэл (буюу エゼキエル (Ээкиэрү))” (*Bilingual Bible*. 1984: 1516) гэжээ. Гэхдээ <https://en.wikipedia.org/wiki/Help:IPA/Hebrew> болон <https://en.wikipedia.org/wiki/Help:IPA/English> галиглах зарчим дээр тулгуурлан эл үгийг “Ээкиэл” хэмээн галиглав.

⁷³ XXXVIII. I-3.

⁷⁴ <https://en.wikipedia.org/wiki/Cimmerians>

⁷⁵ Anderson, 7-р тал.

⁷⁶ XX. 7-8.

⁷⁷ Anderson, 91-104-р тал.

⁷⁸ Тухайн үеийн нэршил. Харин одоогийн Оросын Холбооны Улс.

⁷⁹ Илжигний унага (Монгол хэлний их тайлбар толь буюу <https://mongoltoli.mn/dictionary/detail/35287>).

⁸⁰ Эм илжиг (Монгол хэлний их тайлбар толь буюу <https://mongoltoli.mn/dictionary/detail/35287>).

үр төлөө үлдээсэн газартаа заавал эргэж ирдэг аж⁸¹. Энэ түүхийг Рашид ал-Дин (Rashīd al-Dīn) Огуз Түрэгүүд (Oghuz Turks)-ийн өөрсдийн нь нэрээр нэрлэсэн Огузын Домог (Legend of Oghuz)-т бичжээ. Огуз болон дагалдан яваа хүмүүс цугаар Харанхулуг (Qaranghuluq) буюу нөгөө Харанхуйн Оронд нэвтэрч, унагануудыг нь хилийн зааг дээр зэллэж орхиод, дөрвөн гүү, есөн дудрай унаж очив⁸². Энэ тухай Марко Поло (Marco Polo) ч бас зохиолдоо тэмдэглэн үлдээсэн. Тэрээр Цагаан Орд (White Horde)-ны нутаг (буюу одоогийн Төв Казакстан) буюу Кончийн хаант улс (Conchi's kingdom)-аас умар зүг нэлээн алсад орших “Харанхуй” хэмээн нэрлэгддэг газрын талаар өгүүлжээ. Мөн түүнчлэн тэрээр хэрвээ энэ үнэн бодитой байсан бол “наран үгүй, саран үгүй, одод бас үгүй... харуй бүрийд буй мэт зөвхөн харанхуй бүчих” энэ оронд Татарчууд хэрхэн орж ирэх вэ хэмээн хүүрнэсэн гэдэг. Түүний хэлснээр тэд унагатай гүү унаж, унагануудыг нь энэ газрын захад үлдээн нутгийн гүн рүү явлаа. Тэдгээр гүү унагандаа заавал ирэх учраас буцах замаа хэн хүнээс илүү сайн мэдэх ажээ⁸³.

Эдгээр үлгэрийг дэлгэрүүлэгчид нь хэдийнээ танигдсан Несторын номлогчид бөгөөд тэд Исламын шашин дэлгэрэхээс өмнө Азийн улс орнуудаар Христийн үзэл (Christian faith)-ийг түгээн дэлгэрүүлж явжээ⁸⁴. Энэ урсгалыг Константинопль (Constantinople)-ын тэргүүн хамба лам Нестор (Nestorius) үндэслэсэн бөгөөд Христийн хоёр өөр мөн чанарын тухай гол сургаалыг Эфесийн Зөвлөл (the Council of Ephesus)⁸⁵ 431 онд хуралдаж буруутгасан байдаг. Несторын номлогчид 435 онд Сирийн нэгэн сүмд үйл ажиллагаа явуулах болж, Перс, Месопотами, Араб дахь Ортодоксын Сүм (the Orthodox Church)⁸⁶-ээс ирэх дарамт шахалтаас ангижирсан. Тэдний номлогчид Энэтхэг, Төв Ази болон Алс Дорнодод нэвтрэн орсон байдаг. Бурхны сургаал айлтгагч, гэгээн Томас (St Thomas) шашны сургаалыг өмнөд Энэтхэгт нэвтрүүлсэн гэж үздэг бөгөөд тэр газар өдгөө сири хэлээр сүмийн ёс үйлээ гүйцэтгэдэг “Сирийн Христийн шашинтнууд (Syrian Christians)” буюу угтаа Несторын номлогчдын үр хойчис байдаг аж. Несторын оршуулгын газрууд ч одоогийн Зөвлөлт Холбоот улс⁸⁷-ын харьяанд багтах Төв Ази (Soviet Central Asia)-ийн нутаг дэвсгэрээс олддог. Бидний мэдэж байгаагаар энэхүү Несторын номлогчид Хятад улсад нэлээд хожуу орж иржээ. 1625 онд Жесуитс (Jesuits) 781 оны 2-р сарын 4-ний өдөр барьж дуусгасан нэгэн баганыг Шеньси (Shensi (陝西)) мужийн Сиан (Sian 西安)-аас нээн илрүүлсэн бөгөөд энэ багана дээр сири, хятад хэлээр 635 онд Хятадын шүүхэд Христийн нэгэн номлогч ирсэн хийгээд Танг (T'ang (唐)) улсын эзэн хаан Кау-цунг (Kau-tsung (高宗) (649-83)) Хятадын хэд хэдэн дүүрэгт Христийн сүм барих зөвшөөрлийг олгосон тухай бичжээ. Мөн түүнчлэн уг баганын бичээс дээр 744 онд дараагийн хэдэн номлогчид ирж, 779 онд Сиан-д сүмийн зөвлөгөөн хийсэн тухай тэмдэглэн үлдээжээ⁸⁸. Юутай ч 11-р зууны үед Хятадад Несторын нийгэмлэгүүд байсан ч тэр цаг үеэс хойш төдий л удаагүй юм. Марко

⁸¹ Энэхүү түүхийн Грек хувилбарын орчуулгыг Adolf Ausfeld, *Der griechische Alexanderroman* (Александрын туужийн грек эх), (Leipzig, 1907), 83-4-р талыг үзнэ үү. Тэнд грек эхийн англи орчуулга байхгүй. Нөгөө талаас нь үзвэл 5-р зууны армен хувилбарыг зохиолын уг эхэд нэлээд дөхөж очсон гэж үздэг бөгөөд өдгөө Англи хэлтэн улс оронд илүү дөхөм юм. Albert M. Wolohojian (орчуулав), *The Romance of Alexander the Great by Pseudo-Callisthenes* (Сюдө Келистенийсийн Аугаа Александрын Тууж), (New York, London, 1969)-ийг үзнэ үү. Харамсалтай нь энэ өгүүлбэр (Wolohojian, 115-16-р тал) тэрхүү Арменийн эхээс зөрүүтэй. Дудрайг илэрхийлэх гэсэн гол санаагаар Меркелбах (99-р талд) Энэтхэгчүүд аварга биетэй алт ухдаг шоргоолж (домгийн амьтан)-оос зугтахдаа ингийг хэрхэн ашигладаг байсан талаар Херодот (Herodotus (iii. 102-5-р тал))-т гардаг түүхтэй харьцуулж үзсэн.

⁸² Karl Jahn (орчуулав), *Die geschichte der Oguzen des Rašid ad-Dīn* (Рашид ад-Динны бичсэн Огузын түүх) (Vienna, 1969), 26-р тал.

⁸³ L.F. Benedetto (орчуулав), *The Travels of Marco Polo* (Марко Пологийн аялал), (London, 1931), 387-р тал.

⁸⁴ Несторчуудын тухай үзэхээр бол Bertold Spuler, “Die nestorianische Kirche (Несторын сүм)” *Handbuch der Orientalistik* (Дорно дахины судалгааны гарын авлага) VIII (Leiden, Cologne, 1961), 120-169-р тал.

⁸⁵ Эфес (одоогийн Туркийн Селчук) хотод зарлан хуралдуулсан Христийн шашны хамба нарын зөвлөл. https://en.wikipedia.org/wiki/Council_of_Ephesus

⁸⁶ https://orthodoxwiki.org/Orthodox_Church

⁸⁷ 1974 онд эл өгүүллийг бичиж хэвлүүлж байх үеийн нэршил.

⁸⁸ Сиан (Sian)-д байгаа дурсгалын талаар үзэхээр бол Spuler, 140-р тал; A.C. Moule, *Christians in China before the Year 1550* (1550 оноос өмнөх үеийн Хятад дахь Христийн шашинтан), (London, 1930), 27-52-р тал.

Поло зохиолынхоо цорын гагц гар бичмэлийн нэг хэсэгт Өмнөд Хятадын Фүкиэн (Fukien)-д сууж буй Христийн шашны өвөрмөц урсгалыг баримтлагч нэгэн үндэстнийг тодорхойлон бичсэн нь үнэндээ тэр муждаа олонх нь болж, 17-р зууны үе хүртэл оршин байсан Маникэиен (Manichaeism)⁸⁹-чууд юм⁹⁰. Харин Монгол газар Чингис хааны үе хүртэл Христийн шашин дэлгэрч байсан талаар тодорхой мэдээлэл одоогийн байдлаар бидэнд олдоогүй байна. Гэхдээ хэд хэдэн овог аймаг бүхэлдээ эсвэл зарим хэсэг нь несторын номлогчид байсан талаар бид сонсож байсан удаатай⁹¹. Тэр нь Онгут (Öngüt) аймаг агаад тэд Цагаан хэрмийн хойд талын залгаа нутагтай. Тэр аймгийн нэгэн ханхүү Католик шашинд орсон ч дараа нь Несторын урсгалыг баримтлах болсон. Марко Поло түүнийг ханхүү Жорж (the Prince George) гэх бөгөөд энэ нь уг үгийн Түрэг орчуулга юм⁹². Гэсэн хэдий ч Монголд, онцгойлон Түрэгийн эхэн үе буюу 13-р зуунаас өмнөх үед Христийн шашин дэлгэрсэн талаарх бичмэл мэдээ бидэнд олдоогүй. Цорын гагц баталгаа *Александрын тухай Христийн Домог* (Christian Legend concerning Alexander)-оос салбарлан бичсэн зохиолуудаас олдох магадлал хамгийн өндөр хувьтай юм. 7-р зууны үеийн, нэр нь тодорхойгүй Сирийн Несторын номлогчийн бичсэн тэдгээр зохиолд Зүүн хойд Азийн иргэдэд удаан хугацаанд танил дотно байсан агаад Христийн шашин шүтэх болсон тэдний уг гарвал мартагдаж, өөрсдийн уламжлалыг хэсэг хэсгээр нь дагах болсон.

Орчуулахад ашигласан хэрэглэгдэхүүн

Abdullah Yusuf Ali (орчуулав.) 2000. *The Holly Quran*. Worldworth Editions Limited. Great Britain.

Ариун Библи. 2013. Ариун Бичээс Нийгэмлэг. Улаанбаатар.

Библи. 2015. Монголын Библийн Нийгэмлэг. Улаанбаатар.

Bilingual Bible. 1984. Japanese-English New International Version. World of Life Press. Japan.

Болдбаатар.Ю. 2008. *Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн задын шүтлэг*. Улаанбаатар.

Гонгоржав.Г. 2005. *Монголчуудын чулуун өв соёл*. Улаанбаатар.

Дамдинсүрэн.Ц. 2017. *Сулхарнайн тууж*. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. IV боть. Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой. Улаанбаатар.

Дулам.С. 2018. *“Eriike” хэмээх үгийн гарал хийгээд утга бэлгэдэл*. Бэлгэдэл зүйн судалгаа. МУСУИС. Соёл, Урлаг судлалын сан хөмрөг. Улаанбаатар.

Дулам.С. 2018. *Цагийн бэлгэдэл*. Бэлгэдэл зүйн судалгаа. МУСУИС. Соёл, Урлаг судлалын сан хөмрөг. Улаанбаатар.

Igor de Rachewiltz. 1972. *Index to the Secret History of the Mongols*. Indiana University. Bloomington

Монгол хэлний их тайлбар толь буюу <https://mongoltoli.mn/dictionary/detail>

Монголын эртний түүх. 2017. Тавдугаар боть. Төв Азийн нүүдэлчдийн төр улсууд, МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэн, МУИС-ийн Түүхийн Тэнхим, ШУА-ийн Түүх Археологийн Хүрээлэн. Улаанбаатар.

Oxford Advanced Learner's Dictionary. 2010. 8th edition.

Oxford-Monsudar English-Mongolian dictionary. 2004. 1st edition. Улаанбаатар.

⁸⁹ <https://en.wikipedia.org/wiki/Manichaeism>

⁹⁰ Benedetto, xii-xiii болон 261-3-р талуудыг үзнэ үү.

⁹¹ Одоогийн Улаанбаатар хот орчим газар нутаглаж байсан Хэрэйд (The Kereit) аймгийг 11-р зууны эхээр христийн шашинд орсон гэдэг. Гэсэн хэдий ч Пеллио (Pelliot)-ийн дэвшүүлж буй саналаар зөвхөн 13-р зууны үеийн цаглавар хөтлөгч Бар Ебрае (Bar Hebraeus) энэхүү хэрэйд гэх нэрийг засаж оруулсан байх магадлалтай. Энэ санал бодитой хэдий ч үүнд тайлбар хийх нь төв Азийн ард түмэнд түстэй юм. René Grousset, *The Empire of the Steppes* (Тал нутгийн Эзэнт гүрэн), (New Brunswick, New Jersey, 1970), 191, 578-р талууд, 6-р зүүлт.

⁹² Pelliot, *Notes on Marco Polo* (Марко Пологийн талаарх тайлбар), II, (Paris, 1963), 737-р тал.

Чинбат.Э. 2001. *Англи-Монгол толь*. Улаанбаатар.

<https://mongoltoli.mn/dictionary/detail>

<https://www.livius.org/sources/content/arrian/>

https://en.wikisource.org/wiki/The_Anabasis_of_Alexander

<http://medievalcostumesandgifts.com/medieval-blog/tag/revival-of-learning>

<https://en.wikipedia.org/wiki/Callisthenes>

<https://en.wikipedia.org/wiki/Cleitarchus>

https://en.wikipedia.org/wiki/Alexander_romance

https://en.wikipedia.org/wiki/Julius_Valerius_Alexander_Polemius

<https://en.wikipedia.org/wiki/Naples>

<http://www.thelatinlibrary.com/leo.html>

<https://www.thefreedictionary.com/Manichean>

<https://en.wikipedia.org/wiki/Japheth>

<https://www.thefreedictionary.com/Pahlavi>

https://en.wikipedia.org/wiki/Gog_and_Magog

<https://en.wikipedia.org/wiki/Quran>

<https://en.wikipedia.org/wiki/Friar>

https://mn.wikipedia.org/wiki/эргүнэ_хунгийн_домог

<https://en.wikipedia.org/wiki/Ezekiel>

<https://en.wikipedia.org/wiki/Cimmerians>

https://en.wikipedia.org/wiki/Council_of_Ephesus

https://orthodoxwiki.org/Orthodox_Church

<https://en.wikipedia.org/wiki/Manichaeism>

https://en.wikipedia.org/wiki/Pier_Paolo_Vergerio

https://en.wikipedia.org/wiki/The_Anabasis_of_Alexander

https://en.wikipedia.org/wiki/Gold-digging_ant

https://en.wikipedia.org/wiki/Bar_Hebraeus

<https://en.wikipedia.org/wiki/Help:IPA/Hebrew>

<https://en.wikipedia.org/wiki/Help:IPA/English>

<https://www.goodreads.com/book/show/3092044-the-alexander-book-in-ethiopia>